

**МОНГОЛ ХЭЛНИЙ “АЛИМ” (APPLE) ГЭДЭГ ҮГИЙН ГАРАЛ
ҮҮСЛИЙГ ТУС ҮГИЙН АВИА, ХЭЛБЭР, УТГА БОЛОН
ХЭЛНИЙ ТАРХЦЫН ТАЛААР ЦУВАА ЦАГИЙН ҮҮДНЭЭС
СУДАЛЖ ҮЗСЭН НЬ**

Шиотани Шигэки*

Abstract:

In this paper we attempted to find out the origin of Mongolian word алим “apple” in terms of phonology, morphology, semantics and linguistic distribution.

As a result of the research, some points were made clear as follows:

1. The Written Mongolian form алима “apple” comes from the word of Ancient Turkic almīla ~ alma “apple”, which has a strong possibility of being the borrowing word of Proto-Indo-European language form **ab(e)l-*, because both the Ancient Turkic and PIE forms have the word-initial vowel *a-* and second syllabic-initial consonant being bilabial *b(~p)*, *m* plus liquid sound *l* in common. In other words the Mongolin form алима “apple” is in its PIE origin through the Ancient Turkic language.
2. The Minhe Monguor form амула probably comes from either the metathesis form of the Mongolian form алима within the Mongolic languages, or comes from the haplology form of the Ancient Turkic form almīla (> **amīla* > **amila* > *amula*).
3. From the perspective of meaning within the Mongolic languages, the form алима first appears in *alima* “梨 pear” in Middle Mongolian, and the Modern Central Mongolian dialects such as Khalkha Mongolian, Buryat and Kalmyk languages have the meaning “apple”, while Inner Mongolian, Oirad Mongolian and Dagur languages have the meaning “pear”. In addition in the Mongolic isolated languages such as Baoan, Dongxiang, Kangjia, Monguor (Huzhu, Minhe), Shira Yugur they all have the general meaning “fruit” (broadening (generalization, or extension of

* Япон улс. Осака Их Сургуулийн доктор, профессор. shiotani.shigeki@gmail.com

meaning) from the meaning “pear” or “apple”).

4. As for the other Written Mongolian form jimis “fruit”, it comes from the Ancient Turkic form yemiš “fruit” (< **yemiš*) which also appears in Middle Mongolian and only spreads in some Modern Central Mongolian dialects, but not at all in the Mongolic isolated languages such as Baoan, Dongxiang, Kangjia, Monguor (Huzhu, Minhe), Shira Yugur, and Dagur languages.

5. In terms of semantic changes in Inner Mongolian dialects, the Mongolian form alima, which used to mean “pear” in Middle Mongolian, is used to mean “pear” as before. To avoid homonymic collisions which distinguish alma “apple” from alima “pear”, the form “apple” came to be used as the derivative word almarad that has the same stem alma “apple”.

6. In Khalkha Mongolian dialect, the meaning of the Mongolian form alima was slightly changed to “apple” from “pear” with the appearance of the Chinese loanword liir (лийр) “pear” to avoid semantic collisions between them.

Keywords: Written Mongolian alima, Ancient Turkic almila ~ alma, Minhe Monguor amula, Proto-Indo-European **ab(e)l-*, Meaning of “pear, apple” or “fruit”, Written Mongolian jimis

Эхлэл

Тус өгүүлэлдээ монгол хэлний алим “apple” гэдэг үгийн гарал үүслийг тус үгийн авиа, хэлбэр, утга болон хэлний тархцын талаар цуваа цагийн үүднээс судалж үзэхийг зорилоо. Үүний тул эртний түрэг хэл болон Миньхэ монгол хэлэн дэх тус үгийн байдлыг тусгайлан авч үзлээ. Мөн жимс “fruit” гэсэн үгийн утгын талаар дурдаж улмаар алим “apple”, жимс “fruit” гэдэг хоёр үгийн харьцааг тодруулахыг хичээв.

1. Монгол бичгийн хэлний alima “apple”, эртний түрэг хэлний almila ~ alma “apple” гэдэг хоёр үгийн харьцаа

Тус үгийг авиа болон хэлбэрийн талаар авч үзвэл монгол бичгийн хэлний Мо. alima “apple” гэдэг нь эртний түрэг хэлний АТ. almila ~ alma¹ “apple” гэдэг үгээс орж ирсэн нь тодорхой байгаа бөгөөд дараах байдлаар хувьсаж ирсэн байх гэж таамаглаж байна. Үүнд:

АТ. almila гэдэг анхны хэлбэрээс дараах 2 хэлбэр үүссэн байх гэж бодож байна. Үүнд:

¹ Эртний түрэг хэлний АТ. almila ~ alma “apple” хэлбэрийг Древнетюркский словарь (1969)-аас эш татсан бөгөөд тус толинд үнэндээ толгой үгээр almila (~ alimla) “яблоко”, alma “яблоко” гэж нийтдээ 3 янзаар тэмдэглэсэн нь бий. Харин G.Clauson (1972)-гийн толинд alma, almila гэсэн хоёр үгийг л дурджээ.

① **amīla* (Давхар авиа гээгдэх ёсоор -l-...-l- нийлэмжийн эхнийх нь -l- гээгдсэн хэлбэр: АТ. *al̥mīla* → **amīla*)

② **alīma* (Давхар авиа гээгдэх ёсоор -l-...-l- нийлэмжийн сүүлчийнх нь -l- гээгдсэн хэлбэр: АТ. *almīla* → **almī'a* → **alīma*)

Энэхүү ② **alīma* хэлбэрээс шууд АТ. *alma* (эртний түрэг хэлний бас нэг хэлбэр) үүсэн гарсан бөгөөд Мо. *alima* хэлбэр ч гэсэн үүнээс гарч ирсэн байх боломж маш их байна. Үүнд:

АТ. *almīla* → ② **alīma* → АТ. *alma* → Мо. *alima*

Ташрамд хэлэхэд АТ. *alma* “apple” үгэнд таарахуйц Түрэг төрөл хэлнүүд² дэх одоогийн байдлыг доор үзүүлэв. Жишээ нь: *alma* (Tatar), *alma* (Turkmen), *alma* (Azerbaijani), *алма* (Kazakh), *алма* (Kirghiz) / *elma* (Turkish) / *olma* (Uzbek) гэх мэт.

2. Эртний Түрэг хэлний *almīla* ~ *alma* “apple” гэдэг үгийн гарал үүсэл

Эртний Түрэг хэлний *almīla* ~ *alma* “apple” гэдэг үгийн гарал үүслийн тухай Алтай хэл шинжээч G.Clauson урьд нь зөвхөн “...suggest that this is a loanword, possibly Indo-European”³ гэж дурдсан боловч үүнээс илүү нарийн дурдаагүй билээ. Бид сая дээр дурдсан АТ. *almīla* хэлбэрийн ① **amīla* хэлбэрийг онцлон ажиглаж үзсэний дүнд Эртний Энэтхэг-Европ хэл (Proto-Indo-European language)-ний **ab(e)l-* хэлбэрээс гаралтай гэдгийг доор тодорхой жишээгээр⁴ үзүүлье. Жишээ нь:

apple (English), *Apfel* (German), *appel* (Dutch) / *obuolys* (Lithuanian) / *яблоко* (Russian) / *mela* (Italian), *Malum* (Latin) / *phala* (Sanskrit) “fruit”, *phal* (Hindi) “fruit” гэх мэт.

Энд АТ. *almīla* гэдгийн ① **amīla* хэлбэрийн гарал үүслийг Эртний Энэтхэг-Европ хэл (PIE) **ab(e)l-* хэлбэрээс мөшгөн хөөж үзэх боломжтой учир тэр шалтгааныг нь тодруулахаар судалж үзлээ.

АТ. *almīla* хэлбэрийн ① **amīla* : PIE **ab(e)l-* гэсэн хоёр хэлбэр болон тэдгээрийн төрөл хэлнүүд дэх байдлыг харьцуулан үзсэнээр дараах 2 зүйлийг ажиглаж болох байна.

1-рт: Үгийн эхний эгшиг нь АТ. *a-* (~ *e-* ~ *o-*) : IE. *a-* (~ *e-* ~ *o-*) гэх зэргээр яг тохирч байна.

2-рт: Үгийн дэд үеийн эхний гийгүүлэгч нь АТ. *-m-* : IE. *-b-* (~ *-p-*)

² Түрэг төрөл хэлний жишээнүүдийг ямар толиноос эш татсаныг дурдалгүй орхив.

³ Clauson G. (1972: 146) -гийн толиноос үзнэ үү.

⁴ Энэтхэг-Европ хэлний жишээнүүдийг ямар толиноос эш татсаныг дурдалгүй орхив.

(Зарим үгэнд эхнийх нь: -m- ~ -ph-) гэх зэрэг аль аль нь “хоёр уруулын гийгүүлэгч” байх бөгөөд бүгд араас нь “хэлний хажуугийн гийгүүлэгч” -l- тохиолдож байгаагаараа нийтлэг онцлогтой байна. Иймд АТ. *almīla* гэдгийн ① **amīla* хэлбэрийг Эртний Энэтхэг-Европ хэл (PIE) **ab(e)l-* хэлбэрээс гарал үүсэлтэй гэж дүгнэж болох байна.⁵

3. Монгол төрөл хэлнүүд дэх Мо. alima гэдэг үгийн одоогийн байдал

Монгол төрөл хэлнүүд⁶ дэх тус үгийн одоогийн байдлыг доор үзүүлье.

А. Бичгийн хэлний жишээ:

Мо. alim-a “apple”, ММо. alima (阿里麻) “梨 pear”, Тод бичиг: aliman “梨 pear”

В. Ярианы хэлний жишээ:

Халх монгол:	<u>алим</u> “apple”
Өвөр монгол:	[ælim] “pear”
Ойрад:	[ælmen] “pear”
Халимаг:	<u>альмн</u> “apple”
Буриад:	<u>алима</u> “apple”
Баоань:	<u>alma</u> “fruit, apricot”
Дуншаан:	<u>alima</u> “fruit, pear”
Канжаа:	<u>alima</u> “fruit”
Миньхэ монгол:	<u>amula</u> “fruit”
Хүжү монгол:	<u>alima</u> “fruit, pear”
Зүүн ёгор:	<u>alma</u> “fruit”
Дагуур:	<u>алим</u> “pear”

Дээрх жишээнүүдийн байдлаас үзэхэд монгол төрөл хэлнүүдэд бүгдэд нь Мо. alima хэлбэрийн ул мөр маш түгээмэл бөгөөд баттай хадгалагдаж байгаа нь тодорхой байна.

4. Миньхэ монгол хэлний amula “fruit” гэдэг үгийн учир

Монгол төрөл хэлний нэг болох Миньхэ монгол хэл (Хятадын Цинхай мужийн Миньхэ хотон монгол үндэстний өөртөө засах шяний Гуантин балгасны монголчуудын ярьдаг хэл)-энд *amula* “fruit” гэдэг үг тохиолдож байна. Дээр 3-р бүлэгт дурдсанчлан зөвхөн энэхүү үг нь -m-...-l- гэсэн дэс дарааллаар гарахаас биш бусад хэлнүүдэд бол *alima*, *alim*, *aliman*, *alma* гэх мэтээр -l-...-m- гэсэн дарааллаар гарч байна.

⁵ Дундад үеийн монгол хэлэнд араб, перс зэрэг хэлнээс орсон харь үг нэлээд олон бий. Гэтэл алим “apple”-ыг араб хэлэнд تفاح (tuffāḥ), перс хэлэнд سیب (sīb) гэж хэлдгээс үзэхэд АТ. *almīla* гэдгийн ① **amīla* хэлбэр нь араб, перс хоёр хэлээр дамжихгүйгээр чухам яаж эртний энэтхэг-европ хэлнээс тус хэлэнд орсон нь тодорхойгүй байна.

⁶ Монгол төрөл хэлний жишээнүүдийг ямар толиноос эш татсаныг дурдалгүй орхив.

Иймд яагаад ганцхан Миньхэ монгол хэлэнд л -m-...-l- гэсэн дэс дарааллаар гарсан юм бол гэдэг асуулт аяндаа гарч ирнэ. Үүний учир нь гэвэл монгол төрөл хэлнүүдийн дотроос тус хэлэнд л авиа тонгорсноос өөрөөр хэлбэл l-m хоёр гийгүүлэгч тонгорсноос болж Мо. *alima* > **alma* ~ **aluma* > *amula* гэх мэтээр хувьсаж ирсэн байх боломж маш их байна. Аль эсвэл Эртний Түрэг хэлний *almīla* гэдгийн ① **amīla* хэлбэрээс шууд буюу ① **amīla* хэлбэртэй ямар нэг хэл (энэ нь яг батлагдаагүй ч гэсэн)-нээс: АТ. *almīla* → ① **amīla* → *amula* гэх мэтээр хувьсаж ирсэн боломж ч байсан байж болох юм.

5. Монгол төрөл хэлнүүд дэх Мо. alima гэдэг үгийн илэрхийлдэг утга

Монгол төрөл хэлнүүдийн дотор *alima* гэдэг үгийн хамгийн эртний ул мөр нь дундад үеийн “монгол хятад хэлний үгийн толь” болох Чжи Юань и юй (至元譯語, 1325)-д 《梨 “pear”》阿里馬 *alima*, Хуа-И и юй (華夷譯語, 1389)-д 《梨 “pear”》阿里麻 *alima* гэсэн хэлбэрээр гарч байна. Утгынх нь талаар авч үзэхэд тус үгийн монгол хэлэн дэх анхны утга нь “梨 pear” байсан нь тодорхой боловч Эртний Түрэг хэлний *almīla* ~ *alma* гэдэг үг болон үүнд таарахуйц Түрэг төрөл хэлнүүд дэх тус үгийн утга нь “apple” болохыг харгалзан үзвэл анхны утга нь “apple” юм уу “pear”, үгүй бол “apple”, “pear”-гийн аль алийг нь зааж байсан ч байж магадгүй юм.

Орчин үеийн монгол төрөл хэлний төв хэл аялгуу болох Халх Монгол, Халимаг, Буриад зэрэг хэлэнд тус үг нь “apple” гэсэн утгатай байхад Өвөр Монгол, Ойрад болон салангид хэлний Дагуур хэлэнд “pear” гэсэн утгатай байна.

Монгол төрөл хэлний цөөнх үндэстний салангид хэл болох Баоань, Дуншаан, Канжаа, Монгол (Хүжү, Миньхэ) болон Зүүн ёгор хэлэнд ер нь “fruit” (зарим хэл нь “apricot”, “pear” гэсэн утгыг ч багтаана) гэсэн утгатай бөгөөд үүнийг утгын хувьслын үүднээс үзвэл “apple” юм уу “pear” гэсэн уг утгаас “fruit” гэсэн утгатай болжээ. Үүнийг хэл шинжлэлийн талаас авч үзвэл утга нь өргөжсөн буюу англиар “broadening (generalization, or extension of meaning)” гэж тайлбарлаж болох юм.

6. Монгол бичгийн хэлний jimis “fruit” гэдэг үгийн учир

Орчин цагийн монгол хэлний “fruit” гэсэн утгатай жимс (Мо. jimis) гэдэг үг нь Түрэг гаралтай үг мөн бөгөөд дараах байдлаар хувьсаж ирсэн байх боломжтой юм. Үүнд: Proto-Turkic. *jemiš >

- АТ. yemiš, Tukish: yemiš “fruit” (<АТ., Tukish: ye- “eat”)
- Kyrgyz: жемиш [dʒemiʃ], Kazakh: жеміс [zemis], Tuva: чимис [tʃimis] “fruit”

→ MMo. jimiš, Mo. jimis “fruit”

Энэхүү үг нь анх дундад үеийн монгол хэлний сурвалж бичиг болох 14-р зууны үеийн Мукаддимат Ал-Адаб дээр jimiš “fruit”, Хуа-И и юй (華夷譯語, 1389) дээр 《果“fruit”》者迷失 jemiš(i) гэж гардаг бөгөөд монгол төрөл хэлний дотор Халх Монгол, Өвөр Монгол, Ойрад, Халимаг, Буриад зэрэг төв хэл аялгуунуудад тус үг нь цөм “fruit” гэсэн утгатай тохиолдож байна.

Халх монгол:	<u>жимс</u> “fruit”
Өвөр монгол:	[dʒims] “fruit”
Тод бичиг:	<u>zemis</u> “fruit”
Ойрад:	[zems] “fruit”
Халимаг:	<u>земш</u> “fruit, berry”
Буриад:	<u>жэмэс</u> “fruit, berry”

Харин монгол төрөл хэлний цөөнх үндэстний салангид хэлнүүдэд, тухайлбал Баоань хэлнээс авхуулаад Дуншаан, Канжаа, Монгор (Хүжү, Миньхэ), Зүүн ёгор, Дагуур хэл зэрэгт Mo.jimis гэсэн үгэнд таарах үг огт батлагдаагүй байна.

Энэ байдлыг “хэлний тархац”-ын үүднээс авч үзвэл Mo. alima хэлбэртэй үг нь монгол төрөл хэлний төв хэл аялгуугаар барахгүй, цөөнх үндэстний салангид хэлнүүдэд хүртэл маш түгээмэл тархсан байхад Mo.jimis хэлбэртэй үг нь зөвхөн монгол төрөл хэлний төв хэл аялгуунд л тархсанаас биш, цөөнх үндэстний салангид хэлнүүдэд бол огт тархаагүй гэсэн талаар харилцан эрс ялгаатай байна.

7. Өвөр монгол аялгууны “pear”, “apple” гэдэг утгат хоёр үгийн учир

Өвөр монголын төв аялгуунд “pear” гэдгийг [ælm], “apple” гэдгийг [almārād] гэдэг. Дундад үеийн монгол хэлний сурвалж бичигт alima гэдэг нь анх “梨 pear” гэсэн утгаар гарч байсныг үндэслэвэл тус аялгуунд тэр үеэс эхлэн өдий хүртэл энэхүү үгийн утга нь ер өөрчлөгдөөгүй гэж болох байна.

Харин “apple” гэсэн утгатай үгийн тухайд гэвэл эртнээс нааш Эртний Түрэг хэлээр дамжаар ирсэн АТ. alma “apple”, Mo. alima “pear” гэсэн хоёр үг нь бараг “ижил дуудлагатай үг болох (homonymic collisions)”-оос зайлуулж, нэр үг АТ. alma “apple” дээр олон тооны дагавар -lar залгаснаар alma “apple” + -lar “plural suffix” (алимын төрөл) > *alamdar (voicing -l > -d after consonant m) > *almudar (metathesis of d-r > r-d) > almurad (Mo.) хэлбэр буй болсон болов уу гэж таамаглаж байна. Энэ үг нь бас Казах, Киргиз хэлэнд ч төстэй хэлбэрээр гардгаас энэ нь Түрэг гаралтай үг мөн буй за.

Mo. almurad “apple”

Өвөр монгол: [almārād] “apple”

cf. Kazakh: алмұрт [almort], Kyrgyz: алмурут [almurut] “pear”⁷

8. Халх монгол аялгууны “pear”, “apple” хоёр үгийн учир

Халх монголын аялгуунд “apple” гэдгийг алим, “pear” гэдгийг лийр гэдэг. Дундад үеийн монгол хэлнээс орчин цагийн монгол хэлэнд шилжих үед хятад хэлнээс олон тооны харь үг монгол хэлэнд орж ирсэн бөгөөд тэдгээрийн нэг нь лийр “pear” гэсэн үг байжээ.

Халх монгол: лийр “pear”

Mo. liir “pear” (< Ch. 梨(li) + 儿(r))

Энд Mo. alima “pear”, Mo. liir “pear” хоёр үг нь “ижил утгатай үг болох (semantic collisions)”-оос зайлуулж, тус аялгуунд “pear” гэсэн уг утгаас “apple” болж утга нь бага зэрэг өөрчлөгдсөн байх гэж таамаглаж байна.

Дүгнэлт

Тус өгүүлэлдээ монгол хэлний алим “apple” гэдэг үгийн гарал үүслийг тус үгийн авиа, хэлбэр, утга болон хэлний тархцын талаар цуваа цагийн үүднээс судалж үзсэн билээ. Эртний түрэг хэл болон миньхэ монгол хэлэн дэх тус үгийн байдлыг тусгайлан авч үзэхийн зэрэгцээ жимс “fruit” гэсэн үгийн талаар дурдаж, ялангуяа алим “apple”, жимс “fruit” гэдэг хоёр үгийн харьцааг тодрууллаа.

Судалгааны дүнд дараах зүйлийг тодруулсан болно.

1. Монгол бичгийн хэлний Mo. alima “apple” гэдэг нь Эртний түрэг хэлний AT. almīla ~ alma “apple” гэдэг үгээс орж ирсэн нь тодорхой байна.

AT. almīla гэдэг анхны хэлбэрээс ① *amīla ② *alīma гэсэн 2 хэлбэр үүсэн гарчээ. ② *alīma хэлбэрээс шууд AT. alma хэлбэр үүсэн гарсан бөгөөд Mo. alima хэлбэр ч бас үүнээс гарч ирсэн боломж маш их байна.

Эцэст нь AT. almīla гэдгийн ① *amīla хэлбэрийг Эртний Энэтхэг-Европ хэл (PIE) *ab(e)l- хэлбэрээс гарал үүсэлтэй гэж дүгнэв.

2. Миньхэ монгол хэлний amula хэлбэр нь монгол төрөл хэлний дотор Mo. alima хэлбэрийн “авиа тонгорсон” (metathesis) хэлбэр гэж болох боловч эртний түрэг хэлний AT. almīla хэлбэрийн “давхар авиа гээгдсэн” (haplology)

⁷ Эртний түрэг хэл, одоогийн түрэг хэлэнд armut “pear” гэж гардаг нь перс хэлний amrūd “pear, guava” гэдгийн “авиа тонгорсон” (metathesis) хэлбэр бололтой. Харин Казах, Киргиз хэлэнд тохиолдох “алмұрт, алмурут” зэрэг хэлбэр нь үүнтэй огт холбоогүй гэж таамаглаж байна.

хэлбэр (АТ. almīla > *amīla > *amila > amula) ч байж магадгүй юм.

3. Мо. alima гэдэг үгийн монгол хэлэн дэх анхны утга нь “pear” байсан нь тодорхой боловч Эртний Түрэг хэлний almīla ~ alma гэдэг үг болон үүнд таарахуйц Түрэг төрөл хэлнүүд дэх тус үгийн утга нь “apple” болохыг харгалзан үзвэл анхны утга нь “apple” юм уу “pear”, үгүй бол “apple”, “pear”-ийн аль алийг нь заадаг байсан ч байж магадгүй юм. Тус үг нь орчин үеийн монгол төрөл хэлний төв хэл аялгуу болох Халх Монгол, Халимаг, Буриад зэрэг хэлэнд “apple” гэсэн утгатай байхад Өвөр Монгол, Ойрад болон салангид хэлний Дагуур хэлэнд “pear” гэсэн утгатай байна. Мөн монгол төрөл хэлний цөөнх үндэстний салангид хэл болох Баоань, Дуншаан, Канжаа, Монгор (Хүжү, Миньхэ) болон Зүүн ёгор хэлэнд ер нь “fruit” гэсэн утгатай болжээ.

4. Орчин цагийн монгол хэлний “fruit” гэсэн утгатай жимс (Мо.jimis) гэдэг үг нь түрэг гаралтай үг мөн бөгөөд монгол төрөл хэлний дотор Халх Монгол, Өвөр Монгол, Ойрад, Халимаг, Буриад зэрэг төв хэл аялгуунуудад “fruit” гэсэн утгатай тохиолдож байна. Харин монгол төрөл хэлний цөөнх үндэстний салангид хэлнүүдэд, тухайлбал Баоань хэлнээс авхуулаад Дуншаан, Канжаа, Монгор (Хүжү, Миньхэ), Зүүн ёгор, Дагуур хэл зэрэгт энэхүү үг огт тохиолдохгүй байна.

5. Өвөр монголын төв аялгуунд “pear” гэдгийг [ælim] гэдэг бөгөөд дундад үеийн монгол хэлний alima “梨 pear” гэсэн анхны утга нь тэр үеэс эхлэн өдий хүртэл ер өөрчлөгдөөгүй гэж болох байна. Харин “apple” гэдгийг [almārād] гэх бөгөөд АТ. alma “apple”, Мо. alima “pear” гэдэг хоёр үгийг бараг “ижил дуудлагатай үг болох (homonymic collisions)”-оос зайлуулж, нэр үг АТ. alma “apple” дээр Түрэг хэлний олон тооны дагавар -lar залгаж бүтсэн үг нь цаашид олон хэлбэрээр хувирч, эцэстээ Мо. almurad хэлбэр буй болсон байх гэж таамаглаж байна.

6. Халх монголын аялгуунд “apple” гэдгийг алим, “pear” гэдгийг лийр гэдэг бөгөөд хятад хэлнээс лийр “pear” гэсэн үг орж ирэхээр Мо. alima “pear”, Мо. liir “pear” гэдэг хоёр үг нь “ижил утгатай үг болох (semantic collisions)”-оос зайлуулж, тус аялгуунд “pear” гэсэн уг утгаас “apple” болж утга нь бага зэрэг өөрчлөгдсөн байна.

Ном зүй

Древнетюркский словарь. (1969). Древнетюркский словарь. Академия Наук СССР. Институт Языкознания. Наука. Ленинград. [Ancient Turkic Dictionary. (1969). Academy of Sciences of the USSR. Institute of Linguistics. Nauka. Leningrad.]

Clauson, G. (1972), *An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century*

Turkish, London: Oxford University Press.

Etymonline - Online Etymology Dictionary (<https://etymonline.com>)


Шиотани Шигэки (2024). Миньхэ монгор хэлэн дэх идээ ундааны зарим нэрийн авиа, утгын хувьслын тухай. *Гадаад хэлний сургалтын фронтня*, Vol.7. X. 11-27. Осака. [Shiotani Shigeki (2024). On the Phonetic and Semantic Changes of Some Food and Drink Names in the Minhe Monguor Language. *Frontier of foreign language education*, Vol.7. P. 11-27. Osaka.]

Terasawa Yoshio (2024). *The Kenkyusha Dictionary of English Etymology*. Tokyo: Kenkyusha.

Товчилсон үг:

- AT. Эртний Түрэг хэл (Ancient Turkic)
 Ch. Хятад хэл (Chinese language)
 MMo. Дундад үеийн монгол хэл (Middle Mongolian)
 Mo. Монгол бичгийн хэл (Written Mongolin)
 PIE. Эртний Энэтхэг-Европ хэл (Proto-Indo-European language)

“Авиа, хэлбэрийн хувьсал”-ын талаар хүснэгтээр үзүүлбэл дараах мэт.



Хүснэгт 1.

“Утгын хувьсал”-ын талаар хүснэгтээр үзүүлбэл дараах мэт:

PIE. *ab(e)l- “apple”	→	AT. <u>almila</u> ~ <u>alma</u> “apple”	→	Mo. <u>alima</u> “pear, apple”
Mongolic languages:				
1. “pear” (MMo., Tod., Oirad, Inner Mongolian, Dagur).				
2. “apple” (Other Mongolian central dialects).				
3. “fruit” (Mongolic Isolated languages) [← Extension of meaning of 1. or 2.]				

Хүснэгт 2.

“Авиа, хэлбэр, утгын хувьсал”-ын талаар хүснэгтээр үзүүлбэл дараах мэт:

MMo. <u>alima</u> “pear”	→	Inner Mongolian [ælim] “pear”	MMo. <u>alima</u> “pear”	→	Khalkha Mongolian <u>алим</u> “apple”
→ homonymic collisions			→ semantic collisions.		
AT. > <u>alma</u> “apple”	→	[almărăd]	Ch. 梨(li) + 儿(r) “pear”	→	лийр.

Хүснэгт 3.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.